УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаангом сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: УВА-2026/131/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| | Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь |
| | Утас:70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn |
| | Аудитын менежер: М.Бат-Амгалан |
| Цахим хуудас: www.audit.mn | Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn |
| | Шүрт хайрханы хишиг аудит ХХК-ийн Аудитор: С.Батсайхан |
| Улаангом хот 2026 он | Утас: 88171516, Цахим хаяг: shurtkhairkhaniikhishigaudit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**


**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ..... 3

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ..... 5

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 6

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 8

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 9

2.5.1 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан – Улсын төсөв ..... 10

2.5.2 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан – Орон нутгийн төсөв ..... 12

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ..... 13

3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа ..... 13

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ..... 13

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 14

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ..... 14

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 15

3.5.1 Төсвийн төлөвлөлт ..... 15

3.5.2 Төсвийн гүйцэтгэл ..... 15

**4. АУДИТЫН ТАЙЛАН** ..... 18

4.1 Ерөнхий зүйл ..... 18

4.2 Материаллаг байдал ..... 18

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 18

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 19

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 19

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн ..... 19

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ..... 20

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ..... 20


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

УЛААНГОМ СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
2 ДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Ч.БАТТОГТОХ ТАНАА

2026.02.23 № УВА-2026/131/НА-СТА-ТШЗ
танай______________-ны №________________-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаангом сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Улаангом сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050174

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

9065555 1525010041

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан** /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,160,670,547.99** | **631,887,167.75** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 665,075,844.81 | 63,073,350.59 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 665,075,844.81 | 63,073,350.59 |
| **3121** | **Төгрөг** | 665,075,844.81 | 63,073,350.59 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 665,075,844.81 | 63,073,350.59 |
| **33** | **АВЛАГА** | 1,638,128.00 | 8,039,333.38 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 1,638,128.00 | 6,226,735.00 |
| **335** | **Бусад авлага** | 00.00 | 1,812,598.38 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 00.00 | 1,812,598.38 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 493,956,575.18 | 560,774,483.78 |
| **351** | **Түүхий эд материал** | 106,433,748.77 | 182,026,951.17 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 105,196,348.77 | 181,616,051.17 |
| 35130 | Эм боох материал | 1,237,400.00 | 410,900.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 387,522,826.41 | 378,747,532.61 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 31,095,601.00 | 30,691,390.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 49,370,594.00 | 21,956,700.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 190,000.00 | 00.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 19,264,600.00 | 464,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 6,058,440.00 | 2,521,710.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 281,543,591.41 | 323,113,732.61 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,799,512,792.73** | **4,630,113,280.56** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 4,799,512,792.73 | 4,630,113,280.56 |
| **392** | **Биет хөрөнгө** | 4,279,028,750.13 | 4,112,255,534.80 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 4,246,459,329.29 | 4,246,459,329.29 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -973,495,632.21 | -1,148,531,995.53 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 1,183,003,343.84 | 1,225,199,770.70 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -644,725,713.38 | -668,332,575.17 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 343,493,573.44 | 349,264,683.72 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -250,850,015.04 | -242,067,978.16 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 251,901,841.40 | 251,901,841.40 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -2,607,342.97 | -27,486,907.21 |
| 39217 | Ном | 125,849,365.76 | 125,849,365.76 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 520,484,042.60 | 517,857,745.76 |
| 39301 | Програм хангамж | 14,286,484.00 | 14,286,484.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -982,441.40 | -3,608,738.24 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 507,180,000.00 | 507,180,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **5,960,183,340.72** | **5,262,000,448.31** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **84,752,647.02** | **194,638,066.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 84,752,647.02 | 194,638,066.00 |
| **413** | **Өглөг** | 84,752,647.02 | 194,638,066.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 60,501,821.02 | 00.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 24,250,826.00 | 194,638,066.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 24,250,826.00 | 194,638,066.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **5,875,430,693.70** | **5,067,362,382.31** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 5,875,430,693.70 | 5,067,362,382.31 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,900,863,149.78 | 1,900,863,149.78 |

| | | | |
|---|---|---|---|
| 51101 | Өмч: - төрийн | 1,900,863,149.78 | 1,900,863,149.78 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 3,333,349,415.29 | 2,525,281,103.90 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 3,333,349,415.29 | 3,333,349,415.29 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -808,068,311.39 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 641,218,128.63 | 641,218,128.63 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **5,960,183,340.72** | **5,262,000,448.31** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан** **/төгрөгөөр/**

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **6,985,936,853.50** | **6,891,186,167.74** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **557,155,953.50** | **312,893,467.74** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 557,155,953.50 | 312,893,467.74 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 71,254,689.00 | 92,932,660.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 71,254,689.00 | 72,055,360.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 20,877,300.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **6,428,780,900.00** | **6,578,292,700.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 5,850,961,600.00 | 5,953,060,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 5,850,961,600.00 | 5,953,060,500.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 577,819,300.00 | 625,232,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 577,819,300.00 | 625,232,200.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **6,469,749,280.35** | **7,699,254,479.13** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **6,126,229,699.48** | **7,278,558,669.13** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 6,126,229,699.48 | 7,278,558,669.13 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 4,302,405,017.65 | 4,963,801,771.25 |
| 210101 | Үндсэн цалин | 2,616,537,820.64 | 2,893,496,468.13 |
| 210102 | Нэмэгдэл | 1,361,559,194.64 | 1,498,354,014.46 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 152,196,806.00 |
| 210104 | Урамшуулал | 324,308,002.37 | 419,754,482.66 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 531,029,697.90 | 616,944,412.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 367,697,580.43 | 415,528,012.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 43,120,042.25 | 50,354,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 21,843,041.06 | 25,177,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 19,515,295.71 | 25,177,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 78,853,738.45 | 100,708,400.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 532,793,325.13 | 740,905,120.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 43,739,135.10 | 49,122,574.60 |
| 210302 | Түлш, халаалт | 407,962,515.03 | 598,148,720.40 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 81,091,675.00 | 93,633,825.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 111,618,455.32 | 166,055,910.56 |
| 210401 | Бичиг хэрэг | 48,723,503.00 | 26,763,826.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 00.00 | 190,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 00.00 | 12,183,078.42 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 210,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 35,085,000.00 | 40,728,330.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 1,465,000.00 | 00.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 26,344,952.32 | 85,980,676.14 |
| **2105** | **Нормативт зардал** | 114,908,280.00 | 159,918,480.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 00.00 | 256,350.00 |
| 210502 | Хоол, хүнс | 114,908,280.00 | 159,662,130.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 37,435,100.00 | 64,561,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 37,435,100.00 | 64,561,600.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 11,488,660.00 | 6,771,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 568,000.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 10,920,660.00 | 6,771,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 63,148,973.88 | 103,835,367.15 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,950,600.00 | 22,818,100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 60,198,373.88 | 81,017,267.15 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 421,402,189.60 | 455,765,008.17 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 81,402,257.40 | 2,456,810.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 34,870,641.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 339,999,932.20 | 418,437,557.17 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 343,519,580.87 | 420,695,810.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 343,519,380.00 | 420,695,810.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 263,099,860.00 | 400,099,810.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 80,419,520.00 | 20,596,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 200.87 | 00.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 200.87 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **516,187,573.15** | **-808,068,311.39** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 190885.26 | 0.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 190,885.26 | 00.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **190,885.26** | **-808,068,311.39** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан** **/төгрөгөөр/**

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **3,683,354,389.00** | **6,671,225,360.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **56,252,689.00** | **92,932,660.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 56,252,689.00 | 92,932,660.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 56,252,689.00 | 92,932,660.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 56,252,689.00 | 72,055,360.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 20,877,300.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,627,101,700.00** | **6,578,292,700.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 3,279,944,400.00 | 5,953,060,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 3,279,944,400.00 | 5,953,060,500.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 347,157,300.00 | 625,232,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 347,157,300.00 | 625,232,200.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **3,168,455,949.72** | **7,273,227,854.22** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,168,455,949.72** | **7,273,227,854.22** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **3,039,970,509.72** | **6,861,781,704.22** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,357,456,379.31 | 5,017,869,209.65 |
| 210101 | Үндсэн цалин | 1,532,632,205.26 | 2,947,289,062.53 |
| 210102 | Нэмэгдэл | 672,113,293.53 | 1,498,628,858.46 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 152,196,806.00 |
| 210104 | Урамшуулал | 152,710,880.52 | 419,754,482.66 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 248,117,236.61 | 629,426,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 169,990,298.88 | 428,009,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 19,903,171.13 | 50,354,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,040,372.42 | 25,177,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 9,609,668.96 | 25,177,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 38,573,725.22 | 100,708,400.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 312,580,300.00 | 585,294,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 20,857,483.04 | 49,122,574.60 |
| 210302 | Түлш, халаалт | 267,148,765.33 | 418,596,774.40 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 24,574,051.63 | 117,574,651.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 46,970,950.00 | 161,638,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 46,970,950.00 | 161,638,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,128,000.00 | 39,938,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 4,128,000.00 | 39,938,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 14,535,975.80 | 95,128,945.57 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 1,868,600.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 14,535,975.80 | 93,260,345.57 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 56,181,668.00 | 332,486,949.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 34,074,450.00 | 301,387,749.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 22,107,218.00 | 31,099,200.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **128,485,440.00** | **411,446,150.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 128,485,440.00 | 411,446,150.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 128,485,440.00 | 390,850,150.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 20,596,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **514,898,439.28** | **-602,002,494.22** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 514,898,439.28 | -602,002,494.22 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 438,385,105.02 | 665,075,844.81 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 953,283,544.30 | 63,073,350.59 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 1,900,863,149.78 | 641,218,128.63 | 2,817,327,741.07 | 5,359,409,019.48 |
| **2** | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,900,863,149.78** | **641,218,128.63** | **2,817,327,741.07** | 5,359,409,019.48 |
| **4** | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **5** | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **6** | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 7 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 516,021,674.22 | 516,021,674.22 |
| **8** | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,900,863,149.78** | **641,218,128.63** | **3,333,349,415.29** | 5,875,430,693.70 |
| **9** | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **1,900,863,149.78** | **641,218,128.63** | **3,333,349,415.29** | 5,875,430,693.70 |
| **10** | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **11** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,900,863,149.78** | **641,218,128.63** | **3,333,349,415.29** | 5,875,430,693.70 |
| 12 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **13** | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 14 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 15 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | 0.00 |
| 16 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -808,068,311.39 | -808,068,311.39 |
| 17 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,900,863,149.78** | **641,218,128.63** | **2,525,281,103.90** | 5,067,362,382.31 |

**2.5.1 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан – Улсын төсөв** **/төгрөгөөр/**

| **Код** | **Үзүүлэлт** | **Төлөвлөгөө** | **Төсвийн гүйцэтгэлийн тайлан** | **Гүйцэтгэл зөрүү** | **Хувь** |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 6,768,468,200.0 | 6,647,995,654.2 | 120,472,545.8 | 98.2 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 6,768,468,200.0 | 6,647,995,654.2 | 120,472,545.8 | 98.2 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 6,331,553,900.0 | 6,236,549,504.2 | 95,004,395.8 | 98.5 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 5,077,304,800.0 | 5,017,869,209.7 | 59,435,590.4 | 98.8 |
| 210101 | Үндсэн цалин | 3,183,748,500.0 | 2,947,289,062.5 | 236,459,437.5 | 92.6 |
| 210102 | Нэмэгдэл | 1,561,270,700.0 | 1,498,628,858.5 | 62,641,841.5 | 96.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.0 | 152,196,806.0 | -152,196,806.0 | |
| 210104 | Урамшуулал | 332,285,600.0 | 419,754,482.7 | -87,468,882.7 | 126.3 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 634,663,100.0 | 629,426,000.0 | 5,237,100.0 | 99.2 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 431,570,900.0 | 428,009,600.0 | 3,561,300.0 | 99.2 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 50,773,000.0 | 50,354,000.0 | 419,000.0 | 99.2 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 25,386,500.0 | 25,177,000.0 | 209,500.0 | 99.2 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 25,386,500.0 | 25,177,000.0 | 209,500.0 | 99.2 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 101,546,200.0 | 100,708,400.0 | 837,800.0 | 99.2 |
| **2105** | **Нормативт зардал** | 171,638,400.0 | 161,638,400.0 | 10,000,000.0 | 94.2 |
| 210502 | Хоол, хүнс | 171,638,400.0 | 161,638,400.0 | 10,000,000.0 | 94.2 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 101,205,600.0 | 95,128,945.6 | 6,076,654.4 | 94.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,868,600.0 | 1,868,600.0 | 00.0 | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 99,337,000.0 | 93,260,345.6 | 6,076,654.4 | 93.9 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 346,742,000.0 | 332,486,949.0 | 14,255,051.0 | 95.9 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 315,642,800.0 | 301,387,749.0 | 14,255,051.0 | 95.5 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 31,099,200.0 | 31,099,200.0 | 00.0 | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 436,914,300.0 | 411,446,150.0 | 25,468,150.0 | 94.2 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 436,914,300.0 | 411,446,150.0 | 25,468,150.0 | 94.2 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 416,318,300.0 | 390,850,150.0 | 25,468,150.0 | 93.9 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 20,596,000.0 | 20,596,000.0 | 00.0 | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 6,768,298,860.0 | 6,045,993,160.0 | 722,305,700.0 | 89.3 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 6,675,366,200.0 | 5,953,060,500.0 | 722,305,700.0 | 89.2 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 6,675,366,200.0 | 5,953,060,500.0 | 722,305,700.0 | 89.2 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН** | 92,932,660.0 | 92,932,660.0 | 00.0 | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | | | | |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 72,055,360.0 | 72,055,360.0 | 00.0 | 100.0 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 20,877,300.0 | 20,877,300.0 | 00.0 | 100.0 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.0 | 665,075,844.8 | -665,075,844.8 | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.0 | 63,073,350.6 | -63,073,350.6 | |

**2.5.2 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан – Орон нутгийн төсөв /төгрөгөөр/**

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэл зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **298** | **I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **625,232,200.0** | **625,232,200.0** | **0.0** | **100** |
| **299** | **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | **625,232,200.0** | **625,232,200.0** | **0.0** | **100** |
| **300** | **Бараа, үйлчилгээний зардал** | **625,232,200.0** | **625,232,200.0** | **0.0** | **100** |
| **313** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **585,294,000.0** | **585,294,000.0** | **0.0** | **100** |
| 314 | Гэрэл цахилгаан | 66,957,400.0 | 49,122,574.6 | 17,834,825.4 | 73.4 |
| 315 | Түлш, халаалт | 404,804,200.0 | 418,596,774.4 | -13,792,574.4 | 103.4 |
| 316 | Цэвэр, бохир ус | 113,532,400.0 | 117,574,651.0 | -4,042,251.0 | 103.6 |
| **330** | **Эд хогшил худалдан авах** | **39,938,200.0** | **39,938,200.0** | **0.0** | **100.0** |
| 334 | Урсгал засвар | 39,938,200.0 | 39,938,200.0 | 0.0 | 100.0 |
| **883** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **625,232,200.0** | **625,232,200.0** | **0.0** | **100.00** |
| 889 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 625,232,200.0 | 625,232,200.0 | 0.0 | 100.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улаангом сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, насан туршдаа суралцаж, ажиллах, ёс суртахуунтай, сайн зан чанартай иргэнийг төлөвшүүлэх зорилготой байгууллага юм.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь үйл ажиллагаандаа Боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Татварын ерөнхий хуульд 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагатай гэж үзлээ.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2025 онд Улаангом сумын Ерөнхий боловсролын 2-р суруулийн 2024, 2025 оны эхний 10-р сарын санхүүгийн үйл ажиллагаанд хэсэгчилсэн байдлаар хяналт шалгалт, дотоод аудит хийж дараах зөрчил, дутагдал илрүүлсэн байна. Үүнд

1. Анхан шатны баримтын бүрдэлгүй, нэмэгдэл хөлс олгох журамд заагаагүй 26,358.4 мянган төгрөгийн /илүү цаг/ нэмэгдэл олгосон зөрчилд давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага өгсөн байна.
2. Багш ажилчдад ур чадварын нэмэгдэл олгохдоо журамд заасны ажлын хэсэг байгуулаагүй, шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнээгүй, хавтгайруулж 225,604.6 мянган төгрөг олгосон зөрчилд давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага өгсөн байна.
3. Төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн багшаас бусад орон тооны жишиг нормативаас илүү 2024 онд 3 орон тоо, 2025 онд 3 онд орон тоо /сургалтын менежер, нярав, мужаан, хүний нөөцийн ажилтан/ баталж, цалин, нэмэгдэл, урамшуулалд 104,298.9 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд /ажил олгогчоос/ 12,276.3 мянган төгрөг нийт 116,575.2 мянган төгрөг зарцуулсан зөрчилд давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага өгсөн байна.

Иймд дээрх 3 албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллахыг сургуулийн удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад зөвлөж байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон, шинээр батлагдсан холбогдох хууль, дүрэм, журам, заавар аргачлалын дагуу өөрчлөлтийг тусгаагүй байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаангом сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,518,772.5 мянган төгрөгөөр буюу 2.9 хувиар нэмэгдсэн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт* */мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 665,075.8 | 63,073.4 | (602,002.5) |
| Авлага | 1,638.1 | 8,039.3 | 6,401.2 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 493,956.6 | 560,774.5 | 66,817.9 |
| Үндсэн хөрөнгө | 4,799,512.8 | 4,630,113.3 | (169,399.5) |
| **Нийт хөрөнгө** | 5,960,183.3 | 5,262,000.4 | (698,182.9) |
| Өр төлбөр | 84,752.6 | 194,638.1 | 109,885.4 |
| Засгийн газрын хувь оролцоо | 5,875,430.7 | 5,067,362.4 | (808,068.3) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 5,960,183.3 | 5,262,000.4 | (698,182.9) |

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо, өр төлбөрийн данс байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 63,073.4 мянган төгрөг болж, 602,002.5 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны үлдэгдлийг зарцуулсантай холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 8,039.3 мянган төгрөг болж, 6,401.2 мянган төгрөгөөр өссөн нь ажиллагчидтай холбогдсон авлага 4,588.6 мянга, бусад зардлын тооцооны авлага 1,812.6 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 560,774.5 мянган төгрөг болж, 66,817.9 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал 76,419.7 мянга, бусад хангамжийн материал 41,570.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн, эм боох материал 826.5 мянга, бичиг хэргийн материал 404.2 мянга, аж ахуйн материал 49,370.6 мянга, түлш шатах тослох материал 190.0 мянга, барилгын материал 18,800.6 мянга, хүнсний материал 3,536.7 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,630,113.3 мянган төгрөг болж, 169,399.5 мянган төгрөгөөр буурсан нь машин тоног төхөөрөмж 42,196.4 мянга, тавилга эд хогшил 5,771.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн, тайлант хугацааны үндсэн хөрөнгийн элэгдэл 418,437.5 мянган төгрөгийн зардал гарсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 194,638.1 мянган төгрөг болж, 109,885.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь байгууллагад төлөх өглөг 170,387.2 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 5,067,362.4 мянган төгрөг болж, 808,068.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны санхүүгийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагчийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 8,344,207.7 мянга, орон нутгийн төсвөөс 781,540.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс улсын төсвийн санхүүжилтийг 1,668,841.5 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 156,308.0 мянган төгрөгөөр баталжээ.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 14 хөтөлбөрийн хүрээнд 40 арга хэмжээнд улсын төсвөөс 6,675,366.2 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 72,055.4 мянга, туслах ажиллагааны орлогоос 20,877.3 мянга, орон нутгийн төсвөөс 625,232.2 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 5,953,060.5 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 72,055.4 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 20,877.3 мянга, орон нутгийн төсвөөс 625,232.2 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлжээ.

Улсын төсвийн зардлын гүйцэтгэл 6,647,995.6 мянган төгрөг буюу 98.2 хувьтай, орон нутгийн төсвийн гүйцэтгэл 625,232.2 мянган төгрөг буюу 100 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /Улсын төсөв/ /мянган төгрөг/*

| Д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | Код | Нэр | | | | |
| 1 | 80226 | Байр ашиглалтын үйлчилгээ | 8,188.5 | 8,188.5 | 0.0 | 100 |
| 2 | 80233 | Хүүхэд хамгаалал | 8,422.8 | 7,893.5 | 529.3 | 93.7 |
| 3 | 80312 | Сургалт семинар | 4,510.2 | 4,296.3 | 213.9 | 95.2 |
| 4 | 81605 | Эрүүл мэндийг дэмжих | 8,632.5 | 8,632.5 | 0.0 | 100 |
| 5 | 81801 | Үдийн цай хөтөлбөр | 416,318.1 | 390,850.1 | 25,468.0 | 93.9 |
| 6 | 81806 | Дотуур байрны үйлчилгээ | 480,600.9 | 432,465.3 | 48,135.6 | 89.9 |
| 7 | 81816 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 130,791.8 | 130,731.4 | 60.4 | 100 |
| 8 | 81823 | Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх | 31,103.6 | 19,704.1 | 11,399.5 | 63.3 |
| 9 | 81834 | Боловсролын стандарт, сургалты | 5,150,043.2 | 5,145,429.3 | -4,613.9 | 100 |
| 10 | 81835 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 390,712.1 | 374,326.6 | 16,385.5 | 95.8 |
| 11 | 81844 | Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн | 85,771.1 | 85,759.6 | 11.5 | 100 |
| 12 | 81848 | Сурах бичгийн түрээс | 1,868.6 | 1,868.6 | 0.0 | 100 |
| 13 | 81875 | Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх | 46,042.3 | 43,426.4 | 2,615.9 | 94.3 |
| | | **ДҮН** | **6,763,005.7** | **6,653,572.2** | **109,433.5** | **98.4** |

*Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл / Орон нутгийн төсөв/*

*/мянган төгрөг/*

| д/д | Хөтөлбөр арга хэмжээ | | төлөвлөгөө | гүйцэтгэл | зөрүү | биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | Код | НЭР | | | | |
| 1 | 80111 | Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 625,232.2 | 625,232.2 | 0.0 | 100 |
| | | | 625,232.2 | 625,232.2 | 0.0 | 100 |

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Программ хангамжийн бүртгэл, тайлагнал | 0.0 | 0.0 | Тайлант онд программ хангамж худалдан аваагүй байна. |
| 2 | Унаа хоолны хөнгөлөлт, зардлын тариф | 0.0 | 152,196.8 | Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 1/554 тоот тушаалын дагуу нэг хүнд 1 өдрийн хоол 5.0 мянга, унаа 2.0 мянган төгрөгөөр тооцон олгож байна. |
| 3 | Сургалт, семинар, хурал зөвлөгөөнд зарцуулсан зардал | 0.0 | 0.0 | Тайлант онд сургалт, семинар, хурал зөвлөгөөнд зардал гараагүй байна. |
| 4 | Гадаад томилолт, арга хэмжээнд зарцуулсан зардал | 0.0 | 0.0 | Тайлант онд гадаад томилолтод зардал гараагүй байна. |
| 5 | Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал | 0.0 | 0.0 | Тайлант онд төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал гараагүй байна. |
| 6 | Орон тооны цомхотгол | 0.0 | 0.0 | Тайлант онд орон тооны цомхтгол хийгдээгүй байна. |
| 7 | Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн мэдээлэл | | | Аймгийн 2 телевизтэй гэрээ байгуулан бараа үйлчилгээний бусад зардлаас төлсөн байна. |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Улаангом сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Улаангом сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь тайлант онд дотуур байрны хүүхдийн хоол болон үдийн цайны зардалд худалдан авах ажиллагаа зохион байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Улаангом сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2026 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2026 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн хооронд Шүрт хайрханы хишиг аудит ХХК-ийн аудитор С.Батсайхан гүйцэтгэж, чанарын хяналтыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Намжил, аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Шүрт хайрханы хишиг аудит ХХК-д 2026 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 7,699,254.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 76,992.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг төлөвлөлтийн 80.0 хувиар буюу 61,594.0 мянган төгрөгөөр гүйцэтгэлийн шатанд шинэчлэн тогтоолоо.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Улаангом сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 112 мэдээллээс хугацаандаа оруулсан 94, хугацаа хоцорч оруулсан 18 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

төгрөгөөр

| ДД | Аудитын нэр | Төрөл | Зөрчлийн утга | Шийдвэр | Өгсөн | Хэрэгжилт | Үлдэгдэл |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Улаангом сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит | Санхүүгийн аудит | Захирлын 2024 оны 01-р сарын 03-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар цалин шинэчлэн батлахдаа нягтлан бодогчийн ТҮ-8 ангилал буюу 1114000 төгрөгийн үндсэн цалинг 1448200 төгрөгөөр тогтоож, 1-3 дугаар сард 1733231 төгрөгийн цалин, урамшуулал илүү олгосон байна. | Төлбөрийн акт | 1,733,231.00 | 1,733,231.00 | - |
| 1 | Улаангом сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит | Санхүүгийн аудит | Төрийн үйлчилгээний албан хаагчид илүү цагаар ажилласны нэмэгдэл хөлс 3,552.4 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна. | Зөвлөмж | 3,552,400.00 | 3552400.0 | - |
| | **дүн** | | | | **1,733,231.00** | **1,733,231.00** | |

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Залруулагдаагүй нийт 15,137.6 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 15,137.6 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснийг давтан гаргахгүй байх талаар 2 зөвлөмж өгсөн.

### 5.1. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. *Цалин хөлс, нэмэгдэл урамшуулалтай холбоотой асуудал*

***Илрүүлэлт:*** Хөдөлмөрийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.3-д "Туршилтаар ажиллах ажилтны үндсэн цалинг тухайн ажлын байрны үндсэн цалингаас багагүй байхаар тогтоох бөгөөд түүнд нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал, олговрыг энэ хуульд заасны дагуу олгоно", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан ур чадварын нэмэгдэл олгох журмыг зөрчин шинээр томилогдсон 4 албан хаагчид нийт 5,122.6 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг ажил гүйцэтгэх чадвар, ажлын арга барил, идэвх санаачилгыг харгалзахгүйгээр олгосон байна.

***<u>Өгсөн зөвлөмж:</u>*** Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан ур чадварын нэмэгдэл олгох журмыг мөрдөж ажиллах.

2. Туслах үйл ажиллагааны орлоготой холбоотой асуудал

***Илрүүлэлт:*** Түрээсийн гэрээ байгуулахгүйгээр сургуулийн дотуур байрны хоол үйлдвэрлэлтэй зэрэгцэн багш ажилчид, сурагчдад гал тогооны тогоочоор дамжуулан хоол хийж 10,015.0 мянга төгрөгийн орлого олсон байна.

***<u>Өгсөн зөвлөмж:</u>*** Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу гэрээ байгуулж ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу Төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Шинээр томилогдсон 4 албан хаагчид нийт 5,122.6 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг ажил гүйцэтгэх чадвар, ажлын арга барил, идэвх санаачилгыг харгалзахгүйгээр олгосон байна. | 1 | 5,122.6 | | | | | 1 | 5,122.6 | | | | |
| Түрээсийн гэрээ байгуулахгүйгээр сургуулийн дотуур байрны хоол үйлдвэрлэлтэй зэрэгцэн багш ажилчид, сурагчдад гал тогооны тогоочоор дамжуулан хоол хийж 10,015.0 мянга төгрөгийн орлого олсон байна. | 1 | 10,015.0 | | | | | 1 | 10,015.0 | | | | |
| Дүн | 2 | 15,137.6 | | | | | 2 | 15,137.6 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

"ШҮРТ ХАЙРХАНЫ ХИШИГ АУДИТ" ХХК-ийн АУДИТОР /С.БАТСАЙХАН/

2026 оны 02 дугаар сарын 23-ны өдөр

УВА-2026/131/НА-СТА-ТШЗ